



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга Ц.Шинэхүүг томилсугай.

2. Төрийн өмчийн төлөөлөгчийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Ц.Шинэхүүд даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 04 дүгээр сарын 19-ны
өдрийн А/30 дугаар тушаалын хавсралт

**“ТАВАНТОЛГОЙ ТҮЛШ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОХ
ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БАРИМТЛАХ
УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчит йн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон дараах удирдамжийг баримтална:

1. “Тавантолгой түлш” ХХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэх батлах тухай асуудалд санал өгч оролцох;
2. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж, үнэлэлт дүгнэлт өгөх, гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх;
3. “Тавантолгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудалд санал өгч оролцох;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны зардлын төсөвтэй танилцан, холбогдох хууль тогтоомжийн нийцүүлэх талаар саналаа тусгаж, оролцох;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус 2022 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын “Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн даргыг томилох тухай” 03 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай асуудалд холбогдох хууль тогтоомжийн саналаа өгч оролцох.